




Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сантай хамтран MICS Plus (ОУБТС+) судалгааг 2020 оны 9 сараас хэрэгжүүлж эхэлсэн. ОУБТС+ нь КОВИД-19 цар тахлын үед хүүхэд, гэр бүл, өрхийн нөхцөл байдлыг тодорхойлох өгөгдлийг бий болгож, шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад мэдээлнэ. Энэхүү хормын хувилбарт 2021 оны 04 сарын 13-аас 24-ний хооронд дуудлага хийгдсэн 4-р шатны үр дүнг нэгтгэн харуулав.



Арга зүй, аргачлал

MICS Plus аргачлал нь түүврийн төлөөлөх чадвартай, өрхөд суурилсан статистик судалгааны давуу талыг компьютерийн тусламжтай утсаар ярилцлага (CATI) авах технологийн бодит цаг үеийн мэдээллийг үргэлжилсэн хугацаанд мэдээлэх давуу талтай хослуулсан. Мэдээлэл цуглуулах горим нь судлаач уламжлалт аргаар нүүр тулж ярилцах бус, харин хариулагчтай* шууд утсаар холбогдож мэдээлэл цуглуулах явдал юм.

ОУБТС+ судалгааны аргачлалыг дараах зүйлд үндэслэсэн:


- Өрх/өрхийн гишүүдийн утасны дугаарыг багтаасан өрхийн түүврийн хүрээнээс магадлалт түүврээр өрхийг сонгох
- Сонгогдсон өрх рүү урт хугацаанд шууд дуудлага хийж ярилцлага авах

Судалгааны түүврийг ҮСХ-ны Хүн амын өрхийн мэдээллийн сан (ХАӨМС)-аас авсан. 2020 оны 1-р сарын байдлаар бүртгэлд суурилсан Хүн ам, орон сууцны тооллогыг түүврийн хүрээ болгон ашигласан. Нийт түүврийн хэмжээ 2200 өрх.

Хамрагалтын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор ХАӨМС-ын утасны дугаарыг баталгаажуулах, утасны дугаар байхгүй өрхүүдтэй орон нутгийн хэлтсээр дамжүүлэн холбогдож, хамгийн сүүлийн утасны дугаарыг олж авсан. ОУБТС+ судалгааны эхний шатанд хамрагдаагүй өрхүүдийг орлуулахын тулд загварт суурилсан орлуулах аргыг ашигласан ба дараа дараагийн шатуудад орлуулалт хийглээгүй.

ОУБТС+ нь үндэсний хэмжээний төлөөлөх чадвар бүхий түүврийг ашигладаг. Хот, хөдөө нь түүврийн гол домайн бөгөөд түүврийг дараах байдлаар хуваарилсан. 4 бүс тус бүрээс 400 өрх, Улаанбаатар хотоос 600 өрх. Судалгааны бүх шатанд ижил өрхийг хамруулж, панел дата үүсгэнэ. Судалгааны 4-р шатанд өрхүүд цар тахалын үеэр КОВИД-19 халдвараас өөрийгөө хамгаалах дадал, КОВИД-19 халдвартай холбоотой санаа зовнил, вакцинжуулалт болон шинжилгээнд хамрагдсан байдлын талаар тодруулсан. Өсвөр насны насны хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаар судлах нь 4-р шатны гол сэдэв байв.

Түүврийн хэмжээ, бүсээр



* Өрх бүрт дуудлага хийж судалгааг авахдаа “өрхийн талаар мэдлэгтэй, насанд хүрсэн өрхийн гишүүн”-тэй ярилцсан. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй байдлаар сонгоогүй тул, хариулагчийн өөрийн шинж чанар, үзэл бодол, зан үйлийн хэв маягт үндэслэсэн өгөгдөл нь Монгол улсын насанд хүрсэн нийт хүн амын төлөөлөл болж чадахгүй.



Хураангуй

2021 оны 3-р сарын эхэн үетэй харьцуулахад олон нийтийн газар явахад зайлсхийж байгаа хариулагчдын хувь ижил байгаа бөгөөд ихэнх нь дэлгүүр орох, хувийн байгууллагаар үйлчлүүлэх, эрүүл мэндийн байгууллагад очих шалтгаанаар олон нийтийн газраар явсан гэж хариулсан байна. Хотын хүн амын хувьд, ялангуяа Улаанбаатар хотын хүн ам олон нийтийн газарт хүн хоорондын зай барих нь бага байгаа боловч, амны хаалт зүүх нь бүх нийтийн хэрэглээ хэвээр байна. 2021 оны 3 сарын эхэн үетэй харьцуулахад судалгаанд оролцогчид гэр бүлийн хэн нэгэн гишүүн КОВИД-19-ын халдвар авч хүндээр өвчлөх вий, дараа сарын өрхийн санхүүдээ санаа зовниж буй хувь нэмэгдсэн байна. Судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хувь нь КОВИД-19 халдварын эсрэг вакцины ядаж нэг тунг хийлгэсэн бөгөөд вакцин хийлгээгүй байгаа арван хүний долоо нь вакцин хийлгэнэ гэж хариулсан. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн бараг 4-ны нэг нь 2020 оны 4-р сараас хойш эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хойшуулсан дор хаяж нэг гишүүнтэй байна. Эдгээр хойшуулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ихэнх нь товлолт/урьдчилан сэргийлэх үзлэг, архаг хууч өвчний хяналт, шүдний эмчилгээ, тусламж байна. Энэ шатанд хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын талаар судалсан ба судалгаанд оролцогчдын дийлэнх нь 2020 оны 11-р сараас хойш хүүхдийн биеийн жинд өөрчлөлт орсон эсэхээс үл хамааран хүүхдийн биеийн жингийн асуудалд санаа зовохгүй байна. Хүүхдүүдийн бараг гуравны нэг нь өнгөрсөн долоо хоногт өдөрт дундажаар насандаа тохирсон цагаар унтаж чадаагүй, бага насны хүүхдүүд бага унтаж, арай том хүүхдүүд насандаа тохирсон цагаас илүү цагаар унтаж байна. Хариулагчдын тал хувь нь хүүхдүүдийн өдөрт дундажаар хэдэн цаг ухаалаг утас/ТВ/ компьютер гэх мэт дэлгэц харж өнгөрүүлж байгаа хугацаанд санаа зовж байна.



Судалгааны хэрэгжилт


Хамрагдалтын хувь



Нийт түүврийн зорилтот хэмжээ 2200 өрх гэж тогтоосон бөгөөд 1-р шатанд 344 өрхийг “Ойролцоо хөрш” загварт суурилсан аргаар онцлог шинжийг ашиглан оруулсны дараа хамрагдалтын түвшин 97 хувь байсан. Дараагийн шатуудад эхний шатанд татгалзсан, дуудлагад хариулагч нь сонгогдсон өрхөд амьдардаггүй, сонгогдсон өрх холбоо барих утасгүй, хаяг дээр өрхгүй тохиолдлуудыг хасч 2,154 өрхийг судалгаанд хамруулахыг зорьсон. 4-р шатанд хамрагдалтын хувь 91 буюу хамрагдалт өндөр хэвээр байна. Орлуулалт 1-р шатнаас хойш хийгдээгүй.

Ярилцлагын хугацаа


Ярилцлагын медиан хугацаа, хот хөдөөгөөр



Ярилцлагын үеэр тасалдсаны улмаас 1-р шатанд 191 өрх, 2-р шатанд 203 өрх, 3-р шатанд 316 4-р шатанд 74 өрхийн ярилцлагын үргэлжлэх хугацаа 0-ээс бага эсвэл 60 минутаас их гарсан. Эдгээр өрхүүдийг медиан хугацааг тооцоход оруулаагүй болно.

Дундаж дуудлага хийх оролдлого

Бүрэн авсан ярилцлагын дуудлага хийх оролдлогын дундаж тоо, хот хөдөөгөөр






КОВИД-19

КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газар очихоос зайлсхийх

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй хариулагчийн хувь, 3 болон 4-р шат



Олон нийтийн газар очихоос зайлсхийж огт чадаагүй болон цөөн тохиолдолд чадсан хариулагчийн хувь, олон нийтийн газарт очсон тэргүүлэх шалтгаанаар, 3 болон 4-р шат



КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газарт зай барих

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, ихэвчлэн болон байнга зай бариж чаддаг хариулагчийн хувь, 3 болон 4-р шат



Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга зай барьж чадсан хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 3 болон 4-р шат



КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: олон нийтийн газарт амны хаалт зүүх

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга маск зүүж байсан хариулагчийн хувь, 3 болон 4-р шат

Сүүлийн 7 хоногт олон нийтийн газар очихоос зайлсхийж чадаагүй, олон нийтийн газраар явахдаа ихэвчлэн болон байнга маск зүүж байсан хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 3 болон 4-р шат







КОВИД-19

КОВИД-19 халдвараас сэргийлэх арга хэмжээ: гараа угаах болон ариутгах

Сүүлийн 7 хоногт гараа байнга эсвэл ихэнх тохиолдолд угааж/ариутгаж байсан хариулагчийн хувь, 3 болон 4-р шат




Сүүлийн 7 хоногт гараа байна эсвэл ихэнх тохиолдолд угааж/ариутгаж байсан хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар, 3 болон 4-р шат




КОВИД-19 халдвартай холбоотой санаа зовж буй байдал

Ойр дотны хүн КОВИД-19 тусаж хүндээр өвчлөх вий гэдэгт санаа зовж буй хариулагчийн хувь, 3 болон 4-р шат




Ирэх сарын өрхийн санхүүдээ санаа зовж буй хариулагчийн хувь, 3 болон 4-р шат



КОВИД-19 халдвар илрүүлэх шинжилгээ

Коронавирус илрүүлэх шинжилгээ өгсөн хариулагчийн хувь



Коронавирус илрүүлэх шинжилгээ өгсөн хариулагчийн хувь, сонгосон шинж байдлаар






КОВИД-19

КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт

КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж эхний тунг хийлгэсэн эсэхээр хариулагчийн хувь




КОВИД-19-ийн эсрэг вакцины ядаж эхний тунг хийлгэсэн хариулагчийн хувь, вакцинаар



КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгэх эсэх

КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгээгүй хариулагчийн хувь, КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгэх эсэхээр




КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгээгүй ба КОВИД-19-ийн эсрэг хийлгэнэ гэж хариулсан хариулагчийн хувь, ямар вакцин хийлгэх эсэхээр



КОВИД-19-ийн эсрэг вакцин эргэлзээ

КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгээгүй ба КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгэхгүй эсвэл хийлгэх эсэхээ мэдэхгүй байгаа хариулагчийн хувь



КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгээгүй ба КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгэхгүй эсвэл хийлгэх эсэхээ мэдэхгүй байгаа хариулагчийн хувь, хийлгэхгүй болон эргэлзэж байгаа шалтаанаар



Тэмдэглэл: Вакцин хийлгэхгүй болон хийлгэх эсэхээ мэдэхгүй байгаа шалтгааны талаар асуулт нь олон сонголтой байсан



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Хамгийн ойрын эрүүл мэндийн байгууллага хүртэл явахад зарцуулах дундаж минут, сонгосон шинж байдлаар



19 min



– Улсын дүн

Хөдөө

36

Хот

14

Улаанбаатар

28

Баруун

12

Дээгүүр,

45

Доогуур

9

Байршил

Бүс

Аж байдлын индекс


Хамгийн ойрын эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлдэг өрхүүдийн хувь, хамгийн ойр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ ашигладаг тээврийн хэрэгслээр



Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж болон зардал

Сүүлийн 2 долоо хоногт өрхийн дор хаяж нэг гишүүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах шаардлага гарсан үедээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан өрхийн хувь


Сүүлийн 2 долоо хоногт өрхийн дор хаяж нэг гишүүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах шаардлага гарсан ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой зардал гаргасан өрхийн хувь болон дундаж зардал



Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хойшуулалт

Өрхийн дор хаяж нэг гишүүн 2020 оны 4-р сараас хойш ямар нэгэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ хойшуулсан өрхийн хувь

Өрхийн дор хаяж нэг гишүүн 2020 оны 4-р сараас хойш ямар нэгэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ хойшуулсан өрхийн хувь хойшуулсан тусламж үйлчилгээгээр






Хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд

Насанд хүрэгчдийн хараа хяналтгүй гэртээ үлдсэн хүүхэд

Сүүлийн долоо хоногийн хугацаанд 1 цагаас илүү хугацаагаар ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр харуулж үлдээсэн 0-4 насны хүүхдийн хувь, хүүхдийн насаар


Сүүлийн долоо хоногт насанд хүрэгчдийн хараа хяналтгүй үлдээсэн 0-4 насны хүүхдийн хувь, сонгосон шинж байдлаар



Биеийн жингийн өөрчлөлт

0-4 настай хүүхдийн хувь, 2020 оны 11-р сараас хойш биеийн жин өөрчлөгдсөн эсэхээр (Хариулагчийн мэдээлснээр)


2020 оны 11-р сараас хойш биеийн жин өөрчлөгдсөн 0-4 настай хүүхдийн хувь (Хариулагчийн мэдээлснээр), сонгосон шинж байдлаар



Биеийн жингийн өөрчлөлт

0-4 настай хүүхдийн 2020 оны 11-р сараас хойш биеийн жин өөрчлөгдсөн хүүхдийн хувь, хэрхэн өөрчлөгдсөнөөр (Хариулагчийн мэдээлснээр)

2020 оны 11-р сараас хойш биеийн жин өөрчлөгдсөн 0-4 настай хүүхдийн биеийн жин өөрчлөгдсөнд санаа зовж буй эсэхээрх хариулагчийн хувь






Хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд


Насандаа тохирсон байдлаар унтдаг хүүхэд

0-59 сартай (0-4 настай) хүүхдийн хувь, ажлын өдрүүдэд тогтмол цагт унтдаг эсэхээр




- Огт үгүй
- Цөөн тохиолдолд
- Заримдаа
- Ихэнхдээ
- Байнга

4-59 сартай хүүхдийн хувь, сүүлийн долоо хоногт дунджаар өөрийн насанд тохирсон хугацаагаар унтаж чадсан эсэхээр



- Насандаа тохирсон хугацаанаас бага унтсан
- Насандаа тохирсон хугацаагаар унтсан
- Насандаа тохирсон хугацаанаас их унтсан


4-59 сартай хүүхдийн хувь, сүүлийн долоо хоногт дунджаар өөрийн насанд тохирсон хугацаагаар унтаж чадсан эсэх, хүүхдийн насаар




- Насандаа тохирсон хугацаанаас бага унтсан
- Насандаа тохирсон хугацаагаар унтсан
- Насандаа тохирсон хугацаанаас их унтсан

Дэлгэц харж өнгөрүүлж байгаа хугацаа


0-4 настай хүүхдийн хувь, ухаалаг утас, ТВ, компьютер зэрэг дэлгэц харж өнгөрүүлж буй дундаж хугацаагаар



0-4 настай, ухаалаг утас, ТВ, компьютер зэрэг дэлгэц харж өнгөрүүлж байгаа хүүхдийг дэлгэц харж өнгөрүүлж байгаа хугацаанд нь санаа зовж буй хариулагчийн хувь



Тийм, өдөрт хэтэрхий олон цагийг дэлгэц харж өнгөрөөж байна



Үгүй, санаа зовох хэмжээнд хүрээгүй

ОУБТС+ судалгааны үр дүнгийн дашбоард болон илүү их мэдээллийг дараах хаягаар үзэх боломжтой:

НУБ-ын Хүүхдийн Сангийн MICS Plus олон улсын цахим хуудас
<https://mics.unicef.org/mics-plus/mics-plus-results#mongolia>

Монгол Улсын ҮСХ-ны мэдээллийн цахим хуудас
<https://www.1212.mn/surveymn.aspx>

Үндэсний Статистикийн Хороо



Хаяг: Засгийн газрын III байр, Бага тойруу – 44 Улаанбаатар – 11, Монгол Улс



Утас: (+976) 11-326414



Лавлах утас: 1900-1212



Факс: (+976) 11-324518



Цахим хуудас: www.nso.mn



Цахим шуудан: information@nso.mn



Биднийг дагаарай
Facebook | @StatisticMongolia
Twitter | @Statistic_nso



НУБ-ын Хүүхдийн Сан Монгол дахь оффис



Хаяг: НУБ-ын Нэгдсэн байр, Нэгдсэн Үндэстний гудамж-14, Улаанбаатар 14201, Монгол Улс



Утас: (+976) 11-312217
(+976) 11-312185



Цахим хуудас: www.unicef.org/mongolia



Цахим шуудан: ulaanbaatar@unicef.org



Биднийг дагаарай
Facebook | @unicefmongolia
Twitter | @UNICEF_Mongolia

